

АГУУЛГА

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

2-4 Бодлогын нийтлэл



5-7 Зохицуулалтын мэдээ



8-9 Ярилцлага



10-11 Тогтвортой санхүүжилт

12-13 Компанийн засаглал, комплайнс



13-16 Финтек ба регтек




17-23 Судлаачийн индэр

24-25 Гадаад валютын арилжаа гэж юу вэ?



26-27 Олон улсын зах зээлийн мэдээ



28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Хөрөнгийн өмчлөх эрхээ алдах

Forfeiture

Хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний нөхцөлийг биелүүлээгүйн улмаас эрх, эд хөрөнгө, мөнгөө алдах, хураалгах. Холбогдох хууль–Иргэний хууль.



Хөрөнгө

Asset

Иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа эдийн засгийн үнэ цэнэ бүхий аливаа баялаг. Иргэний хуульд зааснаар хөрөнгө нь эдийн болон эдийн бус баялаг байна. Эдийн баялаг нь эд юмс, эдийн бус баялаг нь оюуны үнэт зүйлс, эрх байна.

Хөдлөх хөрөнгө

Movable property

Биет байдлаар нэг газраас нөгөөд шилжиж болох аливаа төрлийн эд хөрөнгийг хэлнэ. Хөдлөх эд хөрөнгө нь тодорхой байршилд оноогдоогүй, хөдөлгөх, шилжүүлэх боломжтойгоороо үл хөдлөх хөрөнгөөс ялгаатай. Хөдлөх хөрөнгөд холбогдох харилцааг Иргэний хуулиар, хөдлөх хөрөнгийн барьцаатай холбоотой харилцааг тус хууль болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулиар зохицуулж байна.

*Эх сурвалж: Эдийн засаг,
санхүүгийн нэр томъёоны
тайлбар толь*

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

АМЬДРАЛЫН ДААТГАЛ БОЛ ЗАРДАЛ БИШ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Санхүүгийн зөв төлөвлөлт гэдэг нь зөвхөн орлогоо нэмэгдүүлэх тухай ойлголт биш, харин эрсдэлийг удирдах ухаан юм. Хүмүүс амьдралын даатгалыг сар бүрийн “нэмэлт зардал” гэж хардаг. Гэвч бодит байдал дээр энэ нь таны болон таны гэр бүлийн ирээдүйд хийж буй хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт юм.

Даатгалын салбар нь иргэд, аж ахуйн нэгж, төдийгүй улс орны санхүүгийн эрсдэлийн хамгаалалтын чухал дэд бүтэц болохын зэрэгцээ хөрөнгө оруулалтын томоохон эх үүсвэр болж байдаг. Энэ ч утгаараа даатгал нь зах зээлийн үнэ цэнээр тооцогддог харьцангуй богино хугацааны хохирлыг нөхөн төлөх зорилго бүхий ердийн даатгал болон амь нас, хуримтлал гэх мэт урт хугацааны эрсдэл, мөнгөн хөрөнгийн үнэ цэнээр тодорхойлогддог урт хугацааны буюу амьдралын даатгал гэсэн 2 ангилалд хуваагддаг.

Урт хугацааны буюу амьдралын даатгал нь даатгуулагч нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ нь зөвхөн амь насны даатгал биш, мөн эрүүл мэндийн асуудал, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг эрсдэлүүдээс үүдэн даатгуулагчийн орлогыг тасалдалгүй байлгах, улмаар гэр бүл, ойр дотнын хүмүүст нь санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах, түүнчлэн ирээдүйн мөнгөн хуримтлалыг бий болгох хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох зэрэг үүргийг гүйцэтгэдэг цогц даатгалын бүтээгдэхүүн юм. Зарим төрлийн амьдралын даатгал нь хуримтлалын шинж чанартай байдаг тул тодорхой хугацааны дараа буцаан олголт, ашиг хүртэх боломжтой байдаг. Иймээс амьдралын даатгал нь эрсдэлийн хамгаалалт, хуримтлал, урт хугацааны санхүүгийн баталгаа гэсэн гурван үндсэн үүргийг зэрэг гүйцэтгэдэг даатгал билээ.

Амьдралын даатгалын хэрэгцээ шаардлага хувь хүн бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг. Амьдралын даатгал нь залуу гэр бүлүүд, ялангуяа бага насны хүүхэдтэй хүмүүсийн хувьд гэнэтийн эрсдэлээс хамгаалах чухал хэрэгсэл юм. Энэ нь гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ирээдүйд учирч болох эрсдэлүүдийг даван туулахад тусалдаг. Энэхүү даатгалын бүтээгдэхүүн нь таны болон таны гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


2025 оны байдлаар ердийн болон амьдралын даатгалын хураамжийн орлого 584.5 тэрбум төгрөг байгаагаас, амьдралын даатгалын хураамжийн орлого 2 орчим хувийг эзэлж байгаа нь олон улсын түвшинтэй харьцуулахад маш их ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, олон улсад амьдралын даатгалын салбарын гүйцэтгэх үүрэг өндөр байдаг буюу нийт салбарын 55 орчим хувийг эзэлдэг байна.



Амьдралын даатгалын нийт хураамжийн орлогын 33.7 хувийг хугацаат амьдралын даатгал, 29.0 хувийг хуримтлалын даатгал, 27.7 хувийг эрүүл мэндийн даатгал, 9.5 хувийг тэтгэврийн даатгал бүрдүүлж байна.

Даатгалын тухай хууль тогтоомжид амьдралын даатгалын талаарх тодорхойлолт, зохицуулалт нарийвчлан зохицуулагдаагүй байгаагаас улбаалан, даатгуулагч даатгалын гэрээг буруу ойлгох, даатгалын тохиолдол нь гэрээний нөхцөлд хамаарах эсэх талаарх маргаан нэмэгдэх

Амьдралын даатгалын нийт хураамжийн орлого /2025 он/



нөхцөл байдлыг үүсгэж байна. Үүнээс үүдэн энэхүү чухал даатгалын бүтээгдэхүүний хамралт, иргэд, даатгуулагчдын энэ бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагын талаарх ойлголт төдийлөн хангалттай бус байна. Нөгөөтэйгүүр, амьдралын даатгал нь урт хугацаандаа үр ашигтай, тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлагатай, мөн үр ашиг нь урт хугацааны дараа гардаг зэргээс улбаалан энэ салбарт хөрөнгө оруулах сонирхол бага байгаад байна. Өөрөөр хэлбэл, манай улсад 3 урт хугацааны даатгалын компани үйл ажиллагаагаа эрхэлж байгаа тул өрсөлдөөн харьцангуй сул байна.

Түүнчлэн, олон улсад амьдралын даатгалыг хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг нь “Хөрөнгө оруулалтын таатай орчин” гэж үздэг бөгөөд энэ хүрээнд хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгох, тэтгэвэр хуримтлалыг бодлогоор дэмжин ажиллах гээд нэлээдгүй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Урт хугацааны буюу амьдралын даатгалыг хөгжүүлэх хүрээнд сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- ◆ Урт хугацааны даатгагчид хуримтлал барьцаалсан зээл олгох боломжийн талаар олон улсын жишиг, туршлагад суурилсан судалгаа хийж, холбогдох зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн төсөлд тусгасан. Дээрх зохицуулалтыг бий болгосноор амьдралын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ, тус даатгалд даатгуулах сонирхол нэмэгдэх, цаашлаад даатгалын салбарын бүтэц тэнцвэржих эерэг нөлөөг үзүүлэх ач холбогдолтой.
- ◆ Урт хугацааны буюу амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 3 даатгалын компанитай болж иргэн даатгуулагчдад сонголт бий болсон тул ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг зөвхөн урт хугацааны даатгагч эрхлэх шинэчилсэн зохицуулалтыг Даатгалын багц дүрэмдээ тусган, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү шинэчилсэн зохицуулалт 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Шинэчилсэн зохицуулалт хэрэгжиж эхэлснээр даатгалын хамгаалалтын хэмжээ 5–6 дахин нэмэгдэж, даатгуулагчаас гадна түүний гэр бүл дээрх эрсдэлийн улмаас санхүүгийн хүндрэлд орох, орон байраа алдах зэргээс бүрэн хамгаалагдах

боломжтой болсон. Мөн даатгалын гэрээг жил бүр сунгах шаардлагагүй болсноор оролцогч талуудад цаг хугацаа, зардлын хэмнэлт бий болох, ипотекийн даатгалтай холбоотой аливаа маргааны тоо буурах цаашилбал даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдах ач холбогдолтой. Түүнчлэн урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох замаар ипотекийн зээлийн эко системд эерэг нөлөөг үзүүлэх давуу талтай. Шинэчилсэн зохицуулалт хэрэгжиж эхэлснээс хойш 2025 оны байдлаар Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын 5,440 гэрээ байгуулагдаж, 2.0 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлсэн байна.

- ◆ Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд урт хугацааны даатгагч оролцох боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд тусгасан. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар ахмад настнууд олон эх үүсвэр бүхий тогтвортой орлогын эх үүсвэртэй болохын зэрэгцээ урт хугацааны хөрөнгө оруулалтын сангууд бий болсноор хөрөнгийн зах зээл идэвхжиж, санхүү даатгалын салбарт ажлын байр нэмэгдэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдал хангагдаж иргэдийн нийгмийн баталгаа бэхжих бодит нөхцөл бүрдэнэ.

Өнөөдөр хийсэн зөв шийдвэр маргаашийн санхүүгийн тогтвортой байдлыг бий болгодог. **Амьдралын даатгал бол зардал биш — энэ бол таны гэр бүлийн ирээдүйд хийж буй хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт юм.**

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“НИЙСЛЭЛ БОНД”-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЖ ЦАНГ ЦОХИЛОО



Улаанбаатар хотоос олон нийтэд санал болгон гаргаж буй “Нийслэл бонд”-ын анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол 2026.03.30-ны өдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат болон холбогдох албаны бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Дэлхийн том хотууд дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжүүлэх зорилгоор хөрөнгийн зах зээл дээр бонд гаргах нь түгээмэл байдаг. 2021 онд Улаанбаатар хотын эрхзүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар нийслэл хөрөнгийн зах зээлд бонд гаргах эрх зүйн орчин бүрдэж, улмаар 2024 онд анхны нийслэлийн бондыг гаргаж 500 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, нийслэлийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил, ус цэвэрлэх байгууламж Туул-1 коллектор болон үерийн байгууламжийн ажилд зарцуулсан. Харин энэ удаа Засгийн газрын 2026 оны 49 дүгээр тогтоолын дагуу “Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төслийг санхүүжүүлэх зорилгоор 200 тэрбум төгрөг хүртэлх нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд энэ онд багтаан төслийн хэрэгжилттэй уялдуулан үе шаттайгаар арилжаалах, төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг нийслэлийн төсөвт тусгах хүрээнд өнөөдрийн “Нийслэл бонд”-ын арилжааг эхлүүлж цанг цохиж байна. Улаанбаатар хотын цахилгаан, эрчим хүч, дулааны хэрэглээ тогтмол өсөн нэмэгдэж буй энэ үед шинэ дулааны цахилгаан станц байгуулах нь

системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, оргил ачааллын үеийн нөөцийг сайжруулах улмаар аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Нөгөөтэйгүүр дотоодын аж ахуй нэгж, байгууллагууд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол нэмэгдэж, түүнийг дагаад зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр гарч, хөрөнгө оруулагчид ч өргөн сонголттой болж байна. Иймээс Санхүүгийн зохицуулах хороо цаашид ч олон тулгуурт, хүртээмжтэй, ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, санхүүгийн зах зээл дээр олон төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахад бодлого, зохицуулалтын талаас нь үргэлж дэмжин ажиллах болно” гэдгийг онцолсон.

Энэ удаагийн “Нийслэл бонд” нь хүүгийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг, нийслэлийн төсвийн орлогоор баталгааждаг, нийслэлийн өмнө тулгамдсан нийгмийн болон дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулагдахаараа онцлогтой бонд юм.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН 5 ЖИЛИЙН СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг дунд болон урт хугацаанд тогтвортой, үе шаттайгаар хөгжүүлэх, зах зээлийн үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2026.03.30-ны өдөр байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, ОУСК-ийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Маттье Лё Блан нар санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж

бичгийн хүрээнд “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн стратеги боловсруулах төсөл”-ийг хэрэгжүүлж, салбарын хөгжлийн чиглэлийг тодорхойлох 5 жилийн иж бүрэн стратеги боловсруулна. Тодруулбал, хоёр тал хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын жишиг болон ижил түвшний, хөгжингүй зах зээлүүдтэй харьцуулсан үнэлгээ гаргана. Мөн өмнө хэрэгжүүлсэн бодлого, шинэчлэлийн үр нөлөөг үнэлж, цаашдын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын хэрэгжилтийн замын зураглалыг тодорхойлох юм.

Түүнчлэн манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг Дэлхийн банкны “Capital Market Preconditions Framework” – д тулгуурлан үнэлэх бөгөөд бизнесийн орчин, банкны тогтолцооны тогтвортой байдал, хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулагчдын оролцоо, институцийн чадавх, зах зээлийн бүтээгдэхүүн, дэд бүтэц зэрэг үндсэн чиглэлүүдийг хамруулна.

2027 оны аравдугаар сар хүртэл хэрэгжих энэхүү төсөл нь санхүүгийн зах зээлийн хөгжилд бодлогын түвшинд томоохон ахиц авчрах ач холбогдолтой. Үүнд, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг үе шаттай төлөвлөх, олон улсын туршлага, арга зүйг нутагшуулах, зах зээлд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг шинэ шатанд гаргах цаашилбал салбарын цаашдын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд тодорхойлогдох юм.

ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Дэ Нэйче Консерванси (The Nature Conservancy) байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Д.Галбадрах нар тогтвортой, ногоон санхүүжилтийг орон нутагт хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар харилцан

ойлголцлын санамж бичгийг 2026.03.25-ны өдөр байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд орон нутгийн санхүүгийн байгууллагуудаар дамжуулж байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, эдийн засгийн үр ашигтай санхүүгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлд хамтарч ажиллана. Тодруулбал, хоёр тал орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоодод ногоон санхүүгийн бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд бодлогын болон арга зүйн дэмжлэг үзүүлэх, санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэл, эрсдэлийн мэдээлэлд тулгуурлан хамтарсан зөвлөмж, арга хэмжээ хэрэгжүүлэх, ногоон хөгжлийн бодлоготой уялдсан судалгаа, мониторинг хийх юм. Мөн иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын соёлыг нэмэгдүүлэх, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн зорилтыг уялдуулсан тогтвортой хөгжлийн санхүүжилтийг орон нутагт хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах юм.

Дэ Нэйче Консерванси байгууллага нь Монгол Улсад 2008 оноос хойш байгаль хамгаалах чиглэлийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоо “Нутгийн иргэдийн манлайлсан байгаль хамгаалал” төслийн хүрээнд байгалийн нөөцийн хамтын менежментийг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох чиглэлд ажиллаж байна. Харин 2023 оноос эхлэн зорилтот сумдад “Байгалийн нөөцийн хамтын менежментүүдэд хуримтлалын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж санхүүгийн боловсролыг нэмэгдүүлснээр иргэдийн хуримтлалыг нэмэгдүүлэх, улмаар орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоодыг хөгжүүлэх, ногоон бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

“САНХҮҮГИЙН ИННОВАЦ ТЕКСПРИНТ–2026”



УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Санхүүгийн зохицуулах хороо үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд “Санхүүгийн инновац ТекСпринт–2026” уралдааныг амжилттай зохион байгуулж, шилдэг

оролцогчид, шийдлүүдийг шалгарууллаа. Тус уралдаан нь хариуцлагатай зээлийн үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгчдийг санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах, өр төлбөрөө зөв зохицуулахад чиглэсэн технологид суурилсан инновац шийдлүүдийг хөгжүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан болно. Уралдаанд нийт 27 багийн 108 оролцогч бүртгүүлснээс эцсийн шатанд 11 баг шалгарч, өрсөлдсөн юм. Уралдааны хүрээнд оролцогч багууд өгөгдсөн дата мэдээлэл дээр ажиллаж, хэрэглэгчдэд зориулсан санхүүгийн зөвлөх үйлчилгээ, хиймэл оюунд суурилсан чатбот, санхүүгийн боловсролыг дэмжих тоглоомон аппликейшн, мөн санхүүгийн байгууллагуудад зориулсан зээлийн систем, платформ зэрэг олон төрлийн шинэлэг, бүтээлч шийдлийг танилцуулсан юм.

Уралдааны хамтран зохион байгуулагчаар “Лемон Пресс” медиа компани, дэмжигч байгууллагаар “Гэрэл Финанс ББСБ” ХХК, “Бүрэн Скор ЗМС” ХХК, “Мони Маркет Фанд” ХХК, “Фанд Ми Бирж” ХХК, Хаан банкны Инновацийн төв зэрэг байгууллагууд ажиллалаа.

“ЗАЛУУ ҮЕЙНХЭНД САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ”




СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос залуу үеийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор “Залуу үеийнхэнд санхүүгийн мэдлэг олгох” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын онцлог, санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар мэдлэг, мэдээлэл олгосноос гадна санхүүгийн залилан, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замын талаар дэлгэрэнгүй танилцуулсан юм.

Сургалтад Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн оюутан, залуус хамрагдаж, санхүүгийн суурь ойлголтоо нэмэгдүүлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг эзэмшлээ.

БНСУ-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ



БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой зохицуулалтын орчныг бүрдүүлэх зорилгоор БНСУ-ын Үнэт цаасны санхүүжилтийн корпорац (Korea Securities Finance Corporation)-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Санамж бичгийн хүрээнд талууд дээрх чиглэлээр үе шаттай хамтын ажиллагааг өрнүүлэх, техник, эдийн засгийн зөвлөгөө, дэмжлэг авах, хоёр улсын үнэт цаасны зах зээлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцохоор тохиролцсон. Мөн корпорацын мэргэшсэн экспертүүд Санхүүгийн зохицуулах хорооны мэргэжилтнүүд, хөрөнгийн зах зээлийн оролцогчид болон дэд бүтцийн байгууллагын төлөөллийг дунд болон урт хугацааны сургалтад хамруулж, чадавх бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар болсон.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид болон дэд бүтцийн байгууллагуудын төлөөлөл туршлага солилцох, чадавх бэхжүүлэх анхны сургалтад хамрагдлаа. Сургалтын үеэр оролцогчид БНСУ-ын үнэт цаасны санхүүжилтийн үйл ажиллагаа, зах зээлийн дэд бүтэц, эрсдэлийн удирдлага, зохицуулалтын орчны



туршлагатай танилцаж, салбарын томоохон байгууллагуудад ажиллан харилцан мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.

ЯРИЛЦЛАГА

Монголын ХЗХ–д Ази, Номхон далайн бүсийн ногоон санхүүгийн шинэ жишгийг нутагшуулж, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шилдэг туршлагыг бүс нутгийн хэмжээнд хуваалцах боломжтой



*Ранжит Хетарачи
Техникийн багийн захирал
Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)*

ХЗХ–ны салбарын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг та хэрхэн харж байна вэ?

Дэлхийн хэмжээнд 2024 оны байдлаар 101 улсын 67,137 ХЗХ 413.0 сая гишүүнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэн,

тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа боловч хөгжлийн хувьд жигд бус байна. Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU)–ны мэдээллээр энэхүү тоон үзүүлэлтэд Энэтхэг улсын 250.0 сая, БНХАУ–ын 300.0 сая гишүүдийг оруулаагүй болно. Эдгээрийг нэмбэл нийт гишүүдийн тоо **960.0 саяд** хүрнэ. Статистик тоо баримтаас ХЗХ–д улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харж болно. ХЗХ–ны салбар дэлхийн санхүүгийн зах зээлд 5.0 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь нийгмийн эмзэг бүлэгт чиглэн ажилладаг онцлогтой холбоотой. Эдийн засгийн пирамидын суурийг бүрдүүлж буй тэрхүү хэсэг нийт хүн амын 20.0 орчим хувийг төлөөлж байна.

2024 оны байдлаар ХЗХ–дын гишүүдийн тоо өмнөх онтой харьцуулахад 0.4 хувиар, нийт хөрөнгө 2.0 хувиар өссөн байна. Нөгөө талаас, зохицуулалтын болон дижитал шилжилтийн шаардлагын улмаас ХЗХ–нд нэгдэх хандлага эрчимжиж, ХЗХ–дын тоо 2016 оноос хойш анх удаа 70,000 –аас доош буурсан.

ХЗХ–дын өнөөгийн хөгжлийн түвшин бүс нутгийн хувьд

харилцан адилгүй байна. Тухайлбал, 2007–2016 онуудад Африк 85.0 хувь, Ази 78.0 хувь хүртэлх хурдтай өсөлтийг харуулж байгаа бол Хойд Америк, Европ, Номхон далайд нэгтгэх үйл явц давамгайлж байна. АНУ–д нийт актив 2.6 хувь, зээл 0.3 хувиар өссөн ч жижиг ХЗХ–дын гишүүнчлэл буурсан үзүүлэлттэй бол Африкийн ХЗХ–ны салбарыг тэргүүлэгч Кени улсад ХЗХ нь санхүүгийн хүртээмжид онцгой хувь нэмэр оруулсаар байна. Хөгжингүй орнуудад ХЗХ–д банкны түвшний хатуу стандарт, хяналт дор ажилладаг бол БНСУ, Вьетнамаас бусад Азийн ихэнх улс орнуудад Хоршооллын хуулийн хүрээнд зохицуулагдаж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт сул байна.

Хөгжлийн явцад ХЗХ–дод тулгарч буй сорилтын талаар тодруулбал?

ХЗХ–дод тулгарч буй сорилтууд бүс нутгаас хамаарч өөр өөр байна. Жишээлбэл, зохицуулалтын нөхцөл шаардлага, үйл ажиллагааны зардал болон дижитал шилжилт зэргээс хамааран зайлшгүй нэгдэн нийлэх хөдөлгөөн эрчимтэй хөндөгдөж байна. Гишүүдийн тооны өсөлт зогсонги байдалд орсон нь хамгийн тулгамдсан асуудлын нэг гэдгийг салбарын удирдлагуудын 62.0 хувь нь тодорхойлж, ялангуяа жижиг хоршоодод хүчтэй нөлөөлөл үзүүлж байгаа байдал ажиглагдсан талаар дурдсан. Мөн Ази, Номхон далайн бүсийн Филиппин, Индонези, Шри Ланка, Лаос зэрэг орнуудад засаглал тогтолцооны доголдол, гишүүдийн идэвх оролцоо сул, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдал зэрэг олон эрсдэлүүд нөлөөлж байна.

ХЗХ–дын хөгжил, сорилтууд бүс нутгаас хамаарч өөр өөр байгаа ч ирээдүйн хөгжлийн чиг хандлагын хувьд нэг

зорилгод тэмүүлж байна. Гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд гар утасны аппликэйшн, хиймэл оюун ухааны тооцоолол, финтек зэрэг дижитал шилжилт хурдасч байна. Тогтвортой байдлын өсөлт, түүний дотор сэргээгдэх эрчим хүчний ногоон зээл, байгаль орчин, нийгэм, засаглалд тохирох бүтээгдэхүүн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй санхүүжилт зэрэг нь уур амьсгалын ухаалаг хөдөө аж ахуй, Тогтвортой хөгжлийн зорилт 13-тай нийцэж байна. Ёс зүйтэй, бага шимтгэлтэй дижитал үйлчилгээ, Олон улсын хоршооллын холбооны 2026–2030 оны стратеги төлөвлөгөөг ашиглан залуучуудын анхаарлыг ХЗХ-д руу чиглүүлэх тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Мөн нэгдэн нийлэх үйл явц 2026 онд үргэлжлэх төлөвтэй байна.

Та Монгол Улсын ХЗХ-ны салбарын хөгжлийн цаашдын чиг хандлагыг хэрхэн харж байна вэ?

Монголын ХЗХ-ны салбарыг олон улсын түвшинтэй харьцуулахад харьцангуй жижиг, хөгжлийн эхэн шатанд байна. 2011 онд батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад байдаг ба гишүүдийнхээ мөнгөн хөрөнгөөр малчид болон жижиг бүлгүүдэд үйлчилгээ үзүүлж байна. Эдийн засгийн хувьд банкны салбартай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлж, хязгаарлагдмал цар хүрээтэй байгаа нь ажиглагдсан. Мөн багадаа 20 гишүүнтэй ашгийн төлөө бус байгууллага хэлбэрээр, сайн дурын үндсэн дээр нэгдэж, ардчилсан засаглалтай ба гишүүдийн хүрээнд хадгаламж, зээлийн үйлчилгээг өөрийн нөөц хөрөнгийн хэмжээнд үзүүлж байна.

Гол сорилтуудаас дурдвал, хязгаарлагдмал нөөцөөр гишүүдийн зээлийн хэрэгцээг хангах, зарим ХЗХ-ны хувьд гишүүнчлэлээ нэмэгдүүлэх эрмэлзэлгүй, мөн цахимжилт болон дэд бүтцийн сул хөгжлөөс болоод Зээлийн мэдээллийн сан болон МУТСТ тухай хуульд заасан гүйлгээний мэдээллийн нийлүүлэлт удаан байгаа нь эрсдэлийг дагуулна.

Цаашид цахимжилт болон ногоон санхүүжилтийн өсөлтийг эрчимжүүлж 2030 он гэхэд банкнаас бусад санхүүгийн салбарын нийт зээлд эзлэх ногоон зээлийн хэмжээг 5.0 хувьд хүргэх хөтөлбөрийг эрчимжүүлэх шаардлагатай гэж харж байна. Үүний тулд ХЗХ-дын гишүүдийн санхүүгийн болон ногоон санхүүгийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Ингэснээр ХЗХ-д Азийн бусад орны

жишгээр тогтвортой, ногоон санхүүжилтийн зээлд суурилсан шинэ боломжуудыг ашиглах нөхцөл бүрдэнэ.

Та Монголын ХЗХ-дод ногоон санхүүгийн бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд хамтарч ажиллаж байгаа талаараа тодруулж яривал?

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл нь Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтын ажиллагааны хүрээнд ХЗХ-ны салбарт ногоон санхүүгийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх томоохон алхам болж байна. Саяхан хийгдсэн судалгаагаар ХЗХ-дын дийлэнх нь ногоон хадгаламж, ногоон зээлд хамрагдах өндөр сонирхолтой байгаа нь энэ төслийн үндэс болсон. ХЗХ-дод зориулсан ногоон хадгаламж, зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээр донор байгууллагуудын санхүүжилтийг ХЗХ-оор дамжуулах боломж нээгдэнэ. Мөн Санхүүгийн зохицуулах хороо болон Олон улсын санхүүгийн корпорацийн 2025 онд шинэчлэн баталсан санамж бичигтэй уялдуулан БОНЗ стандарт, тогтвортой санхүүжилтийн бодлого ХЗХ-ны салбарт нэвтрүүлэх, 2030 он гэхэд Банкнаас бусад санхүүгийн салбарын нийт зээлд эзлэх ногоон зээлийн хэмжээг 5.0 хувьд хүргэх хөтөлбөрүүдтэй нийцсэн тул төслийн хүрээнд ХЗХ-дод зориулсан ногоон санхүүгийн бүтээгдэхүүн бий болгохоос гадна ХЗХ-дын гишүүдийн уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй дасан зохицох мэдлэгийг дээшлүүлж хариуцлагатай иргэн байх, ХЗХ-д өөрсдийн дотоод үйл ажиллагаанд ногоон байх зарчмыг шингээх цогц ногоон бодлогыг нэвтрүүлэхээр зорьж байна. Ингэснээр ХЗХ-д ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй болох, эрчим хүчний зардлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой санхүүгийн эх үүсвэртэй болсон байхаар төсөөлж байна.

Эцэст нь Монголын ХЗХ-д Ази, Номхон далайн бүсийн ногоон санхүүгийн шинэ жишгийг бий болгож, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаарх сайн туршлагыг бүс нутгийн хэмжээнд хуваалцах боломжтой гэж харж байна.

Ярилцлага өгсөн Танд баярлалаа.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ХЯТАДЫН НОГООН БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ТЭРГҮҮЛЖ БАЙНА

Хятад улс ногоон санхүүжилтийг эрчимтэй хөгжүүлснээр ногоон бондын зах зээлээрээ барууны орнуудыг анх удаа давж, дэлхийд тэргүүлэгч байр суурь эзэлж эхэллээ. Энэ нь тус улс уур амьсгалын зорилгоо хэрэгжүүлэхэд тогтвортой санхүүжилтийг идэвхтэй ашиглаж байгаатай холбоотой юм.

2025 онд Хятад улс 70.3 тэрбум ам.долларын ногоон бонд гаргасан нь түүхэн дээд хэмжээ болсон байна. Энэхүү бондууд нь олон улсын Climate Bonds Initiative байгууллагын стандартын дагуу баталгаажсан эсвэл түүнтэй нийцсэн бондууд юм. Ийнхүү Хятад улс дэлхийн ногоон бондын 17 гаруй хувийг дангаараа бүрдүүлжээ.

Ногоон бонд гэдэг нь компани, банк, засгийн газар зэрэг байгууллагуудын гаргадаг өрийн хэрэгсэл бөгөөд босгосон хөрөнгийг сэргээгдэх эрчим хүч, цэвэр тээвэр, уур амьсгалд тэсвэртэй дэд бүтэц зэрэг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зарцуулах зориулалттай байдаг.

Хятадын ногоон бондын зах зээлийн хурдтай өсөлт нь тус улсын урт хугацааны уур амьсгалын бодлоготой холбоотой. Хятад улс

- 2030 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлыг оргилд хүргэх
- 2060 он гэхэд нүүрстөрөгчийн саармагжилт (carbon neutrality) бий болгох

зорилт тавьсан бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сэргээгдэх эрчим хүч, ногоон дэд бүтэцэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна.

Судлаачдын үзэж байгаагаар Хятадын ногоон санхүүжилтийн зах зээл тэлж буй нь АНУ болон Европт ESG хөрөнгө оруулалтын талаарх улс төрийн маргаан нэмэгдэж, зарим тохиолдолд хөрөнгө оруулалтын идэвх буурч байгаатай зэрэгцэн өрнөж байна. Ийм нөхцөлд Хятад улс ногоон санхүүжилтийн чиглэлээр илүү идэвхтэй байр суурь эзэлж байна.

Хэдийгээр ногоон бондын зах зээл хурдацтай өсөж байгаа ч Хятадын тогтвортой төслүүдийн санхүүжилтийн ихэнх хэсгийг одоогоор ногоон зээл бүрдүүлж байна. Статистик мэдээллээс харахад Хятадад 6 их наяд ам.доллороос давсан ногоон зээлийн үлдэгдэл байгаа бол ногоон бондын хэмжээ харьцангуй бага хэвээр байна.

Гэсэн хэдий ч шинжээчид цаашид Хятадын ногоон бондын зах зээл илүү өргөжнө гэж үзэж байна. Учир нь тус улсын эрчим хүчний дэд бүтцийг шинэчлэх, сэргээгдэх эрчим хүчийг өргөжүүлэхэд дараагийн 25 жилийн хугацаанд 12–14 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцоолжээ.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ: САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ТЕХНОЛОГИЙН НӨЛӨӨ

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан (Artificial Intelligence, AI) нь санхүүгийн салбарт өргөн хэрэглэгдэх болж, тогтвортой санхүүжилтийн хөгжлийг дэмжих чухал технологийн хэрэгсэл болж байна. Тогтвортой санхүүжилт нь байгаль орчин, нийгэм, засаглалын (Environmental, Social, Governance – ESG) хүчин зүйлсийг санхүүгийн шийдвэр гаргалтад тусгах зорилготой бөгөөд дэлхийн санхүүгийн зах зээлд хурдацтай тэлж буй салбаруудын нэг юм.

Олон улсын судалгаанаас харахад 2024 оны байдлаар ESG шалгуурт нийцсэн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 30 их наяд ам.доллороос давсан бөгөөд энэ нь дэлхийн нийт хөрөнгө оруулалтын бараг гурваны нэгтэй тэнцэх хэмжээ юм. AI технологи нь энэхүү өсөн нэмэгдэж буй зах зээлд мэдээллийн боловсруулалт, эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын стратегийг

сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

ESG мэдээллийн шинжилгээнд AI ашиглах боломж

Тогтвортой санхүүжилтийн салбарын гол сорилтуудын нэг нь ESG мэдээллийн хүртээмж, чанар, харьцуулах боломжийн асуудал байдаг. Компаниудын байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг үнэлэхэд их хэмжээний өгөгдөл боловсруулах шаардлагатай бөгөөд уламжлалт аргаар энэ нь ихээхэн хугацаа шаарддаг.

AI технологи нь энэ асуудлыг шийдвэрлэх боломжийг олгож байна. Машин сургалтын алгоритмууд нь компанийн санхүүгийн тайлан, тогтвортой байдлын тайлан, хэвлэл мэдээллийн эх сурвалж болон зах зээлийн мэдээллийг нэгтгэн боловсруулж ESG үзүүлэлтүүдийг илүү нарийвчлалтай үнэлэх боломжийг бүрдүүлдэг.

World Economic Forum-ын судалгаагаар AI технологийг ашигласнаар ESG мэдээллийн боловсруулалтын үр ашиг 40 хүртэл хувиар нэмэгдэх боломжтой гэж үзжээ. Энэ нь хөрөнгө оруулагчдад тогтвортой хөрөнгө оруулалтын шийдвэрийг илүү бодит мэдээлэлд үндэслэн гаргах боломжийг олгодог.

Уур амьсгалын эрсдэлийг үнэлэхэд AI-ийн хэрэглээ

Санхүүгийн байгууллагуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг үнэлэх асуудал улам чухал болж байна. Эдгээр эрсдэлд байгалийн гамшиг, бодлогын өөрчлөлт, технологийн шилжилт зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг.

AI технологи нь эдгээр эрсдэлийг үнэлэхэд өргөн ашиглагдаж эхэлсэн. Жишээлбэл, хиймэл оюун ухаан нь хиймэл дагуулын зураг, цаг уурын мэдээлэл, эдийн засгийн өгөгдлийг нэгтгэн боловсруулж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан таамаглах боломжийг олгодог.

International Monetary Fund-ийн судалгаанд дурдсанаар AI-д суурилсан уур амьсгалын эрсдэлийн загварчлал нь уламжлалт үнэлгээний аргуудтай харьцуулахад эрсдэлийн үнэлгээний нарийвчлалыг 20–30 хувиар сайжруулах боломжтой гэж үзсэн байна.

Тогтвортой хөрөнгө оруулалтын зах зээлд AI-ийн нөлөө

AI технологи нь хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах, санхүүгийн зах зээлийн өгөгдлийг боловсруулах, тогтвортой төслүүдийг тодорхойлох зэрэг олон чиглэлд ашиглагдаж байна.

Organisation for Economic Co-operation and Development-ийн судалгаагаар AI-д суурилсан аналитик системүүдийг ашиглах нь тогтвортой хөрөнгө оруулалтын боломжийг илрүүлэх хугацааг 30–50 хувиар богиносгох боломжтой гэж дүгнэжээ.

Мөн AI нь ногоон болон тогтвортой төслүүдийн санхүүжилтийн үр ашиг, эрсдэлийг үнэлэхэд ашиглагдаж байгаа нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг илүү мэдээлэлд суурилсан, ил тод болгоход нөлөөлж байна.

Ирээдүйн чиг хандлага

AI болон тогтвортой санхүүжилтийн уялдаа цаашид улам нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа дараах чиглэлүүдэд AI технологийн хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна.

- ◆ ESG өгөгдлийн автомат боловсруулалт
- ◆ уур амьсгалын эрсдэлийн нарийвчилсан загварчлал
- ◆ тогтвортой хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах санхүүгийн зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх

United Nations Environment Programme Finance Initiative-ийн тайланд дурдсанаар AI-д суурилсан аналитик системүүдийг ашигласнаар тогтвортой санхүүжилтийн зах зээлд мэдээллийн ил тод байдал болон эрсдэлийн удирдлагыг мэдэгдэхүйц сайжруулах боломжтой байна.

Хиймэл оюун ухаан нь тогтвортой санхүүжилтийн салбарт мэдээллийн боловсруулалт, эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна. ESG мэдээллийн дүн шинжилгээ, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, тогтвортой хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах зэрэгт AI технологийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь тогтвортой санхүүжилтийн зах зээлийн цаашдын хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИНЭЧЛЭЛ: БҮТЭЦ–ҮЙЛ ЯВЦ–СОЁЛОО САЙЖРУУЛАХ НЬ ШИЙДВЭРИЙН ЧАНАРТ НӨЛӨӨЛНӨ

Сүүлийн жилүүдэд төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)–ийн хэлэлцэх асуудал олширч, эрсдэлийн орчин ч хурдтай өөрчлөгдөж байна. Гэвч ТУЗ–ийн хуралдаанд зарцуулах хугацаа хязгаартай тул шийдэл нь “шинэ журам нэмэх” бус, суурь зохион байгуулалтыг зөв болгож, мэдээлэл–хэлэлцүүлэг–шийдвэрийн урсгалыг цэгцлэх явдал юм.

Дараах 3 чиглэл нь үр дүн гаргах боломжийг нэмэгдүүлдэг. Үүнд:

1. Бүрэлдэхүүн ба хороод: “хэрэгтэй ур чадвар”–аа бүрдүүлэх

ТУЗ “зөв хүмүүс”–ээс бүрдэхгүй бол оновчтой шийдвэр гарахгүй. Иймээс эхлээд ТУЗ–д ямар ур чадвар хэрэгтэйгээ тодорхойлох нь зүйтэй.

- ◆ Ур чадварын зураглал гаргах: стратеги, санхүү, эрсдэл, хууль/нийцэл, технологи/кибер, хүний нөөц, салбарын мэдлэг зэрэг чиглэлээр аль хэсэгт дутагдал байгааг бодитоор тодорхойлох.
- ◆ Хороодын зохион байгуулалтыг эргэн харах: хороодын бүтэц, чиг үүрэг нь байгууллагын өнөөгийн эрсдэлийн зурагтай нийцэж байгаа эсэхийг үнэлэх.

Хороодын бодлого (дүрэм)–ыг шинэчлэх: дүрэм, журам нь архивын бичиг биш; аль асуудлыг ямар хороо хариуцах, ямар тайланг ямар давтамжтай авч үзэх зэрэг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлох.



2. Хурлын материал ба хэлэлцэх асуудал: “Гол асуудалд төвлөрөх”

ТУЗ–ийн түгээмэл хүндрэл нь танилцах материал их боловч аль асуудал шийдвэр шаарддаг нь тодорхой ялгарахгүй байх явдал юм. Үүнийг дараах аргаар засах боломжтой.

Хурлын өмнөх материалд нийтлэг шаардлага тогтоох. Тухайлбал:

- ◆ ТУЗ–өөс яг ямар шийдвэр хүсэж байна?
- ◆ Ямар хувилбарууд байна?
- ◆ Эрсдэл ба үр дагавар нь юу вэ?
- ◆ ТУЗ ямар асуултад хариу авах шаардлагатай вэ?

Хэлэлцэх асуудлыг эрэмбэлэх:

- ◆ Шийдвэр шаардсан, чухал асуудлыг эхэнд тавьж, танилцуулах мэдээллийг сүүлд байрлуулна, мөн ижил агуулгатай давхардсан танилцуулгыг багасгах.
- ◆ Давтагддаг, маргаан багатай асуудлыг багцаар нь шийдвэрлэх: ингэснээр чухал асуудалд цаг гаргах.
- ◆ Дохиоллын босго (шалгуур) тогтоох. Ямар үзүүлэлт эсвэл үйл явдал тохиолдвол тухайн асуудлыг ТУЗ/хороонд нэн даруй танилцуулахыг урьдчилан тогтоох.

3. Хэлэлцүүлгийн соёл: “баримтад тулгуурласан маргаан”

ТУЗ–ийн соёл гэдэг нь “эвтэй байх” бус, баримтад тулгуурлан чухал асуудлыг нээлттэй, шүүмжлэлтэй хэлэлцэх чадвар юм.

- ◆ ТУЗ ба гишүүдийн үнэлгээг хэрэгжих ажил болгох: жил бүр үнэлгээ хийгээд дуусгах биш, 1–2 тодорхой сайжруулалтын ажлыг (жишээ нь: материалын стандарт, хороодын дүрэм, журам, ур чадварын зураглалыг шинэчлэх) гаргаж, хэрэгжилтийг хугацаатай хянах.
- ◆ Хэлэлцүүлгийн дүрэм тогтоох: хүн рүү чиглэхээс зайлсхийж, асуудлыг “эрсдэл – баримт – сонголт – үр

дагавар” гэсэн дарааллаар хэлэлцдэг жишиг хэвшүүлэх.

Тогтмол богино сургалт хийх: улирал тутам 20–30 минутын товч танилцуулгаар шинэ эрсдэл, зохицуулалтын өөрчлөлт, шинээр гарч буй практикийн талаар мэдээлэл авч хэвшсэнээр ТУЗ–ийн хэлэлцүүлэг бодит мэдээлэл дээр тулгуурлах нөхцөл сайжирна.

Дүгнэж хэлэхэд, суурь зохион байгуулалтаа оновчтой цэгцлэх нь ТУЗ–ийн шийдвэрийн чанарт шууд нөлөөлдөг байна. Дээр дурдсан 3 чиглэл (ТУЗ–ийн бүрэлдэхүүн, хурлын материал ба хэлэлцэх дараалал, хэлэлцүүлгийн соёл)–ийг бодитоор сайжруулахын тулд байгууллага бүр эхлээд “одоо бид хаана байна вэ?” гэдгээ товч үнэлэх хэрэгтэй. Үүний тулд ТУЗ болон хороод дараах асуултуудыг нэг удаа өөрсдөөсөө асуугаад үзээрэй.

- Манай ТУЗ–д хамгийн их дутагдаж буй 1–2 ур чадвар юу вэ?
- Хороодын чиг үүрэг бодитоор хэрэгжиж байна уу, эсвэл цаасан дээр үлдэх хандлагатай юу?
- Хурлын материал дээр “яг ямар шийдвэр” гэдэг нь эхнээсээ тодорхой байдаг уу?
- Хэлэлцэх асуудлын дараалал хамгийн чухал асуудлаасаа эхэлдэг үү?
- Давтагддаг, маргаан багатай асуудлыг багцаар баталж, чухал асуудалд цаг гаргаж чаддаг уу?
- Эрсдэлийн дохиоллын босго (ямар үед ТУЗ оролцох вэ) тодорхой юу?

–ТУЗ/гишүүдийн үнэлгээ бодит сайжруулалт болж хувирч, хэрэгжилт нь хугацаатай хянагддаг уу?

ФИНТЕК БА РЕГТЕК

ШИЛДЭГ 10: КРИПТОВАЛЮТ




Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт дэлхий даяар байгууллагууд болон хувь хүмүүсийн өргөнөөр ашиглаж буй хамгийн түгээмэл криптовалютуудыг онцлон хүргэж байна.

Өнөөдөр дэлхийн санхүүгийн зах зээлд томоохон бүтцийн өөрчлөлт өрнөж байна. Урьд нь криптовалют нь туршилтын шинжтэй, өндөр эрсдэлтэй арилжаанд хамаарагддаг байсан бол одоо томоохон байгууллагуудын хөрөнгө оруулалтын салшгүй нэг хэсэг болжээ.

Нийтлэл бэлтгэж буй энэ үед криптовалютын зах зээлийн нийт үнэлгээ 23.8 их наяд ам.долларт хүрээд байна. Энэ өсөлт нь компаниуд болон хөрөнгө оруулалтын сангууд криптовалют руу илүү идэвхтэй хандаж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж буйтай холбоотой юм.

Мөн төвлөрсөн бус санхүү (DeFi) эрчимтэй хөгжиж, шинэ төрлийн шийдлүүд бий болсоор байна. Үүний үр дүнд уламжлалт банкны систем болон блокчэйн технологийн хоорондын ялгаа багасаж, харилцан уялдаа холбоо нь улам бүр бэхжиж байна. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.



10. TRON (TRX)

Зах зээлд нэвтэрсэн он: 2013 он

Зах зээлийн үнэлгээ: 26.31 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: TRON Foundation

TRON нь төвлөрсөн бус веб орчинд том байр суурь эзэлсэн бөгөөд ялангуяа энтертаймент болон контент хуваалцах салбарт түлхүү ашиглагддаг. Зуучлагчгүйгээр ажилладаг гэдгээрээ онцлог тул уран бүтээлчид өөрсдийн контентоос шууд хэрэглэгчдээс орлого олох боломжтой байдаг. Энэ нь DeFi салбарт өргөн хэрэглэгдэж буй загвар юм.

Мөн TRON сүлжээ нь хурдан ажиллагаатай, шимтгэл бага учраас стэйблкойны гүйлгээнд түгээмэл ашиглагддаг. Ялангуяа хөгжиж буй орнуудын хэрэглэгчид бага зардлаар, хурдан хугацаанд хил дамнасан гүйлгээ хийхэд тохиромжтой шийдэл болдог.



9. Dogecoin (DOGE)

Зах зээлд нэвтэрсэн он: 2013 он

Зах зээлийн үнэлгээ: 16.60 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагчид: Billy Markus, Jackson Palmer

Анх криптовалютын эхний үеийн хэт хөөрөгдөлд хариу болгож, хошигнол хэлбэрээр бүтээгдсэн Dogecoin нь хүлээлтийг давж, салбартаа тогтвортой байр суурь эзэлсэн криптовалют болж чадсан. Цаг хугацааны явцад түүний хэрэглээ өргөжиж, томоохон компаниуд албан ёсны төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах болсноор финтек салбарт бодит үүрэгтэй болсон.

Бусад олон криптовалютаас ялгаатай нь Dogecoin нь нийлүүлэлт нь байнга нэмэгддэг бүтэцтэй бөгөөд хадгалахаас илүү зарцуулахыг дэмжих зорилготой. Энэ нь дижитал валютын салбарт өвөрмөц туршилт болж энгийн хэрэглэгчид болон жижиг хөрөнгө оруулагчдын идэвхтэй дэмжлэгийн ачаар хөгжиж байна.



8. Bitcoin Cash (BCH)

Зах зээлд нэвтэрсэн он: 2017 он

Зах зээлийн үнэлгээ: 10.03 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагчид: Бие даасан

Bitcoin Cash нь анхны Bitcoin-ийн удаан гүйлгээ, өндөр

шимтгэлийн асуудлыг шийдэх зорилгоор бий болсон. Блокчийн хэмжээг томруулснаар гүйлгээ илүү хурдан хийгдэж, шимтгэл нь бага болсон.

Иймээс Bitcoin Cash нь зөвхөн хадгалах хөрөнгө биш, харин өдөр тутмын төлбөр хийхэд илүү тохиромжтой криптовалюта юм. Энэ нь худалдаачид болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд блокчийн технологийг амархан ашиглах боломж олгодог.

7. Solana (SOL)



Зах зээлд нэвтэрсэн он: 2020 он

Зах зээлийн үнэлгээ: 50.17 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: Solana Labs

Гүйцэтгэх захирал: Anatoly Yakovenko

Solana нь хурд, гүйцэтгэл сайтай гэдгээрээ алдартай криптовалюта юм. Энэ нь “proof-of-history” гэх онцгой технологийг ашигладаг бөгөөд үүний ачаар секундэд маш олон гүйлгээг боловсруулах боломжтой. Тиймээс төвлөрсөн бус аппликейшн (dApp) болон NFT зах зээлд өргөн ашиглагддаг.

Финтек салбарын хувьд Solana нь өндөр хүчин чадалтай сүлжээ гэж үзэгддэг. Учир нь хурдан гүйлгээ, бага зардал нь нарийн төвөгтэй санхүүгийн үйлдлүүд болон өндөр давтамжтай арилжаа хийхэд тохиромжтой орчныг бүрдүүлдэг.

6. USD Coin (USDC)



Зах зээлд нэвтэрсэн он: 2018 он

Зах зээлийн үнэлгээ: 70.65 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: Centre

(Circle Ч Coinbase)

Гүйцэтгэх захирал: Jeremy Allaire

USDC нь ам.доллороор баталгаажсан стэйблкойн бөгөөд уламжлалт банкны систем болон дижитал хөрөнгийн ертөнцийг холбох гүүр болдог. Нөөц хөрөнгөөр бүрэн баталгаажсан, мөн тогтмол хөндлөнгийн хяналт шалгалтад хамрагддаг тул ил тод байдлаараа өндөр үнэлэгддэг.

DeFi орчинд USDC нь үнэ тогтвортой “тооцооны нэгж” болж

хэрэглэгчдэд үнийн савлагаанд өртөхгүйгээр зээл олгох, зээл авах, арилжаа хийх боломж олгодог. Мөн дүрэм, зохицуулалтыг чухалчилсан хандлага нь байгууллагын хөрөнгө оруулагчдад илүү найдвартай сонголт болдог.



5. XRP (XRP)

Зах зээлд нэвтэрсэн он: 2012 он

Зах зээлийн үнэлгээ: 82.69 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: Ripple

Гүйцэтгэх захирал: Brad Garlinghouse

XRP нь олон улсын банк хоорондын гүйлгээг илүү хурдан, хямд болгох зорилгоор бүтээгдсэн. Энэ нь “төлбөр түргэн гүйцэтгэх чадварын гүүр” болж ажилладаг тул санхүүгийн байгууллагууд хил дамнасан гүйлгээг хэдхэн секундэд, уламжлалт SWIFT системтэй харьцуулахад илүү бага зардлаар гүйцэтгэх боломжтой.

Зохицуулалтын зарим хүндрэлтэй тулгарч байсан ч Ripple-ийн технологи нь финтек болон криптовалютын огтлолцолд чухал байр суурь эзэлсээр байна. Энэ нь блокчийн технологийг уламжлалт санхүүгийн системтэй уялдуулж, дэлхийн санхүүгийн урсгалыг илүү хурдан, үр ашигтай болгох боломжийг бүрдүүлж байна.

4. BNB (BNB)



Зах зээлд нэвтэрсэн он: 2017 он

Зах зээлийн үнэлгээ: 91.86 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: Binance

Гүйцэтгэх захирал: Yi He (хамтран үүсгэн байгуулагч)

BNB нь дэлхийн хамгийн том крипто биржүүдийн нэг болох Binance-ийн үндсэн токен юм. Анх арилжааны шимтгэлийг хямдруулахад ашиглагддаг байсан ч одоо BNB Chain сүлжээг ажиллуулахад чухал үүрэг гүйцэтгэж DeFi төрлийн олон үйлчилгээ хөгжих “суурь платформ” болсон.

Мөн BNB нь тодорхой хугацаанд койны тоог “шатаах” механизмаар нийлүүлэлтээ багасгадаг. Энэ нь үнэ цэнийг хадгалах, өсгөхөд нөлөөлдөг. Иймээс BNB нь платформд суурилсан токен хэрхэн дэлхийн хэмжээний санхүүгийн

системийн нэг хэсэг болж чаддагийн сайн жишээ юм.



3. Tether (USDT)

Зах зээлд нэвтэрсэн он: 2014 он

Зах зээлийн үнэлгээ: 185.48 тэрбум ам.доллар

Үүсгэн байгуулагч байгууллага: Tether Limited

Гүйцэтгэх захирал: Paolo Ardoino

Tether (USDT) нь дэлхий дээр хамгийн өргөн хэрэглэгддэг, хөрвөх чадвар өндөртэй стэйблкойн юм. Энэ нь ам.доллартой 1:1 харьцаатай холбогддог тул үнэ нь тогтвортой байдаг. Иймээс хэрэглэгчид криптовалютын үнийн савлагаанаас түр зайлсхийхдээ крипто орчноос гаралгүйгээр USDT руу шилжих боломжтой.

DeFi салбарт USDT нь чухал үүрэг гүйцэтгэж, ихэнх бирж болон санхүүгийн үйлчилгээний платформуудын хөрвөх чадварын гол эх үүсвэр болдог. Мөн үндэсний мөнгөн тэмдэгт нь тогтворгүй орнуудад хил дамнасан мөнгөн шилжүүлэг хийхэд өргөн ашиглагддаг.

2. Ethereum (ETH)



Зах зээлд нэвтэрсэн он: 2015 он

Зах зээлийн үнэлгээ: 245.43 тэрбум ам.доллар*

Үүсгэн байгуулагч байгууллага: Ethereum Foundation

Үүсгэн байгуулагч: Vitalik Buterin

Ethereum нь орчин үеийн DeFi –ийн үндсэн суурийг тавьсан

платформ юм. Bitcoin нь ихэвчлэн дижитал мөнгөний үүрэгтэй байдаг бол Ethereum нь програмчлагдах боломжтой блокчэйн бөгөөд “ухаалаг гэрээ” (smart contract)–г нэвтрүүлснээрээ онцлог. Эдгээр нь автоматаар хэрэгждэг гэрээ бөгөөд бирж, зээлийн платформ, даатгалын систем зэрэг олон үйлчилгээний үндэс болдог.

Proof-of-stake системд шилжсэнээр Ethereum–ийн эрчим хүчний хэрэглээ эрс багасаж, байгаль орчинд илүү ээлтэй болсон. Үүний улмаас байгууллагын хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүү татах болсон.

Мөн хөгжүүлэгчдийн экосистемийн тасралтгүй шинэчлэлтийн ачаар Ethereum нь санхүүгийн инновац болон бодит хөрөнгийг токенжуулах (дижитал хэлбэрт шилжүүлэх) гол платформ хэвээр байна.



1. Bitcoin (BTC)

Зах зээлд нэвтэрсэн он: 2009 он

Зах зээлийн үнэлгээ: 1.38 их наяд ам.доллар*

Үүсгэн байгуулагчид: Бие даасан

Блокчэйн технологийн анхдагч болох Bitcoin

нь зах зээлийг тэргүүлсэн хэвээр бөгөөд “дижитал алт” гэж үзэгддэг. Нийт 21 сая ширхгээр хязгаарлагдсан тул уламжлалт мөнгөний үнэ цэнэ буурах нөлөөнөөс хамгаалах боломжтой. Энэ онцлог нь сүүлийн үед томоохон компаниуд болон тэтгэврийн сангуудын сонирхлыг ихээр татаж байна.

АНУ–д Bitcoin–д суурилсан спот ETF гарч ирсэн нь түүнийг дэлхийн санхүүгийн зах зээлд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн чухал хөрөнгө болгож байна.

Мөн зөвхөн үнэ хадгалах хэрэгсэл байхаас гадна Lightning Network зэрэг Layer 2 шийдлүүд хөгжиж, илүү хурдан, бага зардлаар төлбөр хийх боломжийг нээж байна. Энэ нь Bitcoin –ийг финтек салбарын тэргүүлэгч байр суурийг хэвээр хадгалж байна.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10/top-10-cryptocurrencies>

СУДЛААЧИЙН ИНДЭР

ФИНТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СЭНДБОКСЫН ДАРААХ ЗОХИЦУУЛАЛТ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.

Гүйцэтгэсэн:

СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга, Б.Батчимэг, batchimeg_b@frc.mn
СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны ахлах мэргэжилтэн, Э.Элбэгзаяа, elbegzaya@frc.mn
СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн, О.Мичидмаа michidmaa_o@frc.mn

ХУРААНГУЙ

Технологид суурилсан санхүүгийн салбар хурдацтай өсөн, технологийн шинэчлэл, зохицуулалтын өөрчлөлтүүдийг авчирч байна. Энэ салбар нь уламжлалт санхүүгийн үйлчилгээний хязгаарлалтыг давж, илүү хүртээмжтэй, үр ашигтай, аюулгүй санхүүгийн орчныг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ улс орнууд шинээр бий болж буй эрсдэл, боломжид нийцүүлэн нэгдсэн “Финтекийн тухай хууль” батлах, салбар тус бүрийн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зохицуулалтын сэндбокс зэрэг туршилтын уян хатан механизмыг нэвтрүүлэх зэрэг олон төрлийн зохицуулалтын арга хэрэгсэл ашиглаж байна. Монгол Улсад финтекийн салбар эрчимтэй хөгжиж байгаа ч салбаруудын хууль, эрх зүйн шинэчлэл хурдтай бус байгаагаас шалтгаалан шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд туршилтаас хэтэрч зах зээлд бүрэн эрхтэйгээр нэвтрэхэд эрх зүйн орчин тодорхой бус, хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь инновацыг удаашруулах, хөрөнгө оруулагчдын итгэл сулрах, хэрэглэгчийн эрх зүйн хамгаалалт хангалтгүй байх зэрэг эрсдэлийг дагуулж байна. Энэхүү судалгаа нь Мексик, Сингапур, БНСУ, Казахстан, Их Британи зэрэг найман орны финтекийн зохицуулалтын эрх зүйн тогтолцоог харьцуулан судалж, тэдгээрийн сэндбоксын дараах үеийн зохицуулалтын шийдэл, тусгай зөвшөөрлийн аргачлал, эрх зүйн механизмыг авч үзсэн болно.

УДИРТГАЛ

Сүүлийн арван жилд финтек буюу санхүүгийн технологийн хурдацтай хөгжил нь дэлхийн санхүүгийн тогтолцооны бүтэц, үйлчилгээний хэлбэрийг эрс өөрчилж, санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, хурдан, зардал багатай болгохын зэрэгцээ уламжлалт санхүүгийн байгууллагуудад шинэ өрсөлдөөн бий болгож байна. Цахим сүлжээ, гар утасны технологи, өгөгдлийн дүн шинжилгээ, блокчэйн, хиймэл оюун ухаан зэрэг технологийн дэвшил нь хөгжиж буй орнуудад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн болон төлбөр тооцооны үйлчилгээг өргөжүүлэх боломж бүрдүүлж байгаа бол хөгжингүй орнуудад хэрэглэгч төвтэй, өгөгдөлд суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэж байна. Олон улсын туршлагаас харахад финтекийг зохицуулахад улс орнууд нэгдсэн хууль батлах, одоо мөрдөгдөж буй салбарын хуулиудыг шинэчлэх, эсвэл туршилтын орчинд суурилсан уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх зэрэг өөр өөр арга барил ашиглаж байна. Монгол Улсад финтекийн салбар эрчимтэй хөгжиж байгаа боловч эрх зүйн орчин бүрэн төлөвшөөгүй, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалт тодорхой бус хэвээр байна. Иймээс энэхүү судалгаагаар финтекийн зохицуулалтын олон улсын туршлагыг харьцуулан судалж, сэндбоксын дараах зохицуулалтын механизмыг тодорхойлох замаар Монгол Улсад инновацыг дэмжсэн, эрсдэлд суурилсан финтекийн зохицуулалтын загварыг боловсруулахад чиглэсэн дүгнэлт, бодлогын санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛ

Финтекийн зах зээлийн хөгжил нь технологийн дэвшил болон санхүүгийн салбарын өөрчлөлттэй уялдан үе шаттайгаар хөгжиж ирсэн. Судалгаанд финтекийн хөгжлийг ерөнхийд нь цахимжуулалтын суурь бүрдсэн үе, хэрэглэгч төвтэй цахим үйлчилгээний өргөжилт, бие даасан финтек экосистемийн бүрэлдэх үе, төрийн бодлоготой уялдсан хөгжлийн үе, мөн уялдсан зохицуулалт бүхий дижитал санхүүгийн орчны үе зэрэг хэд хэдэн шаттайгаар тайлбарладаг. Эхний шатанд банк, санхүүгийн байгууллагууд дотоод үйл ажиллагаагаа автоматжуулах технологи нэвтрүүлж байсан бол 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа хэрэглэгч төвтэй, технологид суурилсан шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээ эрчимтэй хөгжиж эхэлсэн. Харин сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан, блокчэйн, өгөгдлийн дүн шинжилгээ, нээлттэй санхүүгийн холболт зэрэг технологид тулгуурлан финтек нь уламжлалт санхүүгийн тогтолцоотой зэрэгцэн бие даасан экосистем болон хөгжиж байна.

УЛС ОРНУУДЫН ЗОХИЦУУЛАЛТ

Финтекийн хөгжил нь дэлхийн санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлт авчирч, улс орнуудын хувьд эрх зүйн орчноо шинэчлэх шаардлагыг бий болгож байгаа бөгөөд финтекийн үйлчилгээ нь уламжлалт банк, даатгал, хөрөнгө оруулалт, төлбөрийн системийг дижитал хэлбэрээр орлох буюу нөхөх боломжтой болсон нь зохицуулалтын шинэ хандлагыг шаардах болсон. Улс орнуудын зохицуулалтын туршлагаас үзвэл эрсдэлд суурилсан зохицуулалт хэрэгжүүлэх, инновацыг дэмжсэн уян хатан орчин бүрдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг нийтлэг зарчмуудыг баримталж байна. Гэсэн хэдий ч эдгээр зарчмыг хэрэгжүүлэх арга барил нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо, институтийн чадавх, зах зээлийн хөгжлийн түвшнээс шалтгаалан ялгаатай байдаг.

Тодруулбал, зарим орнууд финтекийн үйл ажиллагааг тусгайлсан хууль буюу бие даасан эрх зүйн зохицуулалтаар зохицуулдаг бол зарим улсуудын хувьд одоо мөрдөгдөж буй

Финтекийн зах зээлд цахим төлбөр тооцоо, зээлийн платформ, хөрөнгө оруулалтын автомат зөвлөгч үйлчилгээ, хамтын санхүүжилт, даатгалын технологи, нээлттэй санхүү, дижитал хөрөнгө болон төвлөрөлгүй санхүү зэрэг олон төрлийн үйлчилгээ хөгжиж, санхүүгийн үйлчилгээний хэлбэрийг эрс өөрчилж байна. Эдгээр шинэ үйлчилгээ нь хиймэл оюун ухаан, блокчэйн, өгөгдлийн дүн шинжилгээ, үүлэн тооцоолол, нээлттэй программ хангамжийн холболт зэрэг технологид тулгуурлан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах боломжийг бүрдүүлж байна. Гэвч финтекийн хурдтай хөгжил нь санхүүгийн мэдээллийн аюулгүй байдал, хэрэглэгчийн хамгаалалт, зах зээлийн эрсдэлийн удирдлага зэрэг шинэ зохицуулалтын шаардлагыг бий болгож байгаа бөгөөд улс орнуудын хувьд инновацыг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах тэнцвэртэй эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ улам нэмэгдэж байна.

салбарын хуулиудыг шинэчлэх замаар зохицуулдаг байна. Мөн инновацыг дэмжих зорилгоор зохицуулалтын туршилтын орчин буюу сэндбокс, инновацын төв, зөвлөгөөний нэгж зэрэг механизмуудыг өргөн ашигладаг. Финтекийн зохицуулалтыг бүс нутгаар авч үзвэл, Европын бүсэд нэгдсэн дижитал санхүүгийн бодлого, крипто хөрөнгийн зохицуулалт хөгжиж байгаа бол Ази, Номхон далайн бүсэд инновацад нээлттэй, уян хатан зохицуулалт давамгайлж байна. Харин Хойд ба Латин Америк, Зүүн Европ, Төв Ази, Африк болон Ойрх Дорнодын орнууд финтекийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, туршилтын зохицуулалтын механизм нэвтрүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг бий болгож байна.

Мексик Улс: 2018 онд баталсан Финтекийн тухай хуулиар финтекийн үйл ажиллагааг нэгтгэсэн эрх зүйн хүрээнд зохицуулж, цахим мөнгө, хамтын санхүүжилт, нээлттэй өгөгдөл зэрэг үйлчилгээнд тусгай зөвшөөрөл, хяналтын тогтолцоог бий болгосон. Мөн туршилтын орчин (сэндбокс) –ыг хуульчилж, амжилттай туршигдсан бүтээгдэхүүнийг

холбогдох зөвшөөрлийн үндсэн дээр зах зээлд нэвтрүүлэх боломж олгодог.

Бүгд Найрамдах Солонгос Улс: Финтекийн үйл ажиллагааг олон салбарын хуулийн хүрээнд зохицуулж, төлбөрийн үйлчилгээ, өгөгдөл хамгаалалт, нээлттэй санхүү зэрэг чиглэлд эрсдэлд суурилсан уян хатан зохицуулалтын бодлого хэрэгжүүлдэг. “Шинэлэг санхүүгийн үйлчилгээний тухай хууль”-аар сэндрокс механизмыг нэвтрүүлж, шинэ үйлчилгээг туршсаны дараа тусгай зөвшөөрөл авах эсвэл зохицуулалтын өөрчлөлт хийх боломжийг бүрдүүлдэг.

Казахстан Улс: Финтекийн зохицуулалтыг Астана олон улсын санхүүгийн төвийн тусгай бүсийн эрх зүйн орчинд хэрэгжүүлж, английн эрх зүйн зарчимд тулгуурласан уян хатан зохицуулалтын системийг ашигладаг. Сэндрокс болон түр зөвшөөрлийн тогтолцоогоор шинэ үйлчилгээг туршиж, шаардлагатай тохиолдолд бүрэн зөвшөөрөл эсвэл тусгай финтек лиценз олгодог.

Сингапур Улс: Финтекийн үйл ажиллагааг төв банкны нэгдсэн зохицуулалтын хүрээнд хуулиудад уялдаатай байдлаар зохицуулж, эрсдэлд суурилсан, инновацыг дэмжсэн бодлого хэрэгжүүлдэг. Сэндроксоор туршигдсан үйлчилгээ нь холбогдох хууль, лицензийн бүх шаардлагыг хангасны үндсэн дээр зах зээлд нэвтрэх шаталсан зохицуулалтын тогтолцоотой.

Япон Улс: Финтекийн салбарыг тусгай нэг хууль бус, харин банк, төлбөрийн үйлчилгээ, мэдээлэл хамгаалалт зэрэг уламжлалт санхүүгийн хуулиудын хүрээнд зохицуулдаг. Сэндроксын туршилтаар баталгаажсан шинэ үйлчилгээнд зохицуулалтын заавар гаргах эсвэл холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар зах зээлд нэвтрүүлэх боломжийг

бүрдүүлдэг.

Филиппин Улс: Финтекийн зохицуулалт нь төв банк, үнэт цаасны зохицуулагч болон бусад байгууллагуудын хамтарсан хяналтын хүрээнд хэрэгжиж, цахим төлбөр, дижитал банк, цахим хэтэвч зэрэг үйлчилгээнд лиценз олгодог. Сэндроксод туршигдсан үйлчилгээ нь банк бус санхүүгийн байгууллагын лиценз авах, санхүүгийн байгууллагатай хамтрах эсвэл шинэ төрлийн зөвшөөрлөөр зах зээлд нэвтрдэг.

Их Британи Улс: Финтекийн үйл ажиллагааг Санхүүгийн үйлчилгээ ба зах зээлийн тухай хуулийн хүрээнд эрсдэлд суурилсан, зарчимд тулгуурласан уян хатан зохицуулалтын загвараар хэрэгжүүлдэг. Сэндрокс нь бүтээгдэхүүн туршиг зорилготой бөгөөд амжилттай туршигдсан үйлчилгээ нь бүх зохицуулалтын шаардлагыг ханган албан ёсны зөвшөөрөл авч зах зээлд нэвтрэх ёстой.

Швейцар Улс: Финтекийн үйл ажиллагааг банк, хөрөнгө оруулалт, өгөгдөл хамгаалалт зэрэг уламжлалт санхүүгийн хуулийн хүрээнд үйл ажиллагаанд суурилсан зарчмаар зохицуулж, инновацыг дэмжсэн уян хатан орчныг бүрдүүлдэг. Мөн финтекийн тусгай зөвшөөрөл болон криптовалют, блокчэйнд чиглэсэн бодлогоор технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмждэг.

Финтекийн зохицуулалтын олон улсын туршлагаас харахад улс орнууд туршилтын зохицуулалтын орчин буюу сэндроксыг нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх, инновацыг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, мөн хил дамнанас зохицуулалтын уялдааг бий болгох гэх мэт зохицуулалтын чиг хандлага давамгайлж байна.

МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад финтек салбар сүүлийн жилүүдэд харьцангуй хурдацтай хөгжиж, дижитал төлбөр тооцоо, цахим зээл, блокчэйн болон иргэдийн санхүүгийн менежментийн платформууд өргөжин хөгжиж байгаа бөгөөд мобайл төлбөрийн систем, өгөгдөл солилцооны интерфэйс, блокчэйн технологи зэрэг шийдлүүд санхүүгийн салбарт ашиглагдаж эхэлсэн. Монгол Улсын хувьд финтекийн үйлчилгээг холбогдох салбарын хууль

тогтоомжуудын хүрээнд зохицуулж байгаа бөгөөд 2021 оноос хойш сэндроксын зохицуулалтыг нэвтрүүлж, хэрэгжүүлж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар тус сэндроксын орчинд хэд хэдэн байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байгаа хэдий ч амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин хангалтгүй хэвээр байна. Мөн салбарын хууль тогтоомжууд нь үйл ажиллагааны төрлийг нарийвчлан заасан байдаг тул шинэ үйлчилгээ нэвтрэх бүрд хуульд

өөрчлөлт оруулах шаардлага үүсдэг нь зохицуулалтын уян хатан байдлыг хязгаарлаж байна.

Иймд шинэ төрлийн финтек үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх бүрт хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж, зохицуулалтын хугацаа удаашрах асуудал тулгарч байгаа бөгөөд энэ нөхцөл байдлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх зорилгоор санхүүгийн зохицуулагч байгууллагуудад түр зохицуулалт хэрэгжүүлэх эрх олгосон боловч урт хугацаанд шинэ үйлчилгээний онцлогт нийцсэн тогтвортой эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага хэвээр байна.

ФИНТЕКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Технологийн хурдтай хөгжил, дижитал санхүүгийн үйлчилгээний тэлэлттэй уялдан илүү уян хатан, эрсдэлд суурилсан зохицуулалтын тогтолцоо руу шилжиж байна. Олон улсын туршлагаас харахад Их Британи, Сингапур, Швейцар зэрэг орнууд технологид төвийг сахисан, инновацыг дэмжсэн бодлого хэрэгжүүлснээр финтекийн хөрөнгө оруулалт, хөгжлийн төв болж байгаа бол зарим орнууд бүтээгдэхүүн төвтэй, илүү нарийвчилсан хуульчилсан зохицуулалтыг ашиглан зах зээлийн тогтвортой байдал, эрсдэлийн удирдлагыг хангахыг зорьж байна. Финтекийн зохицуулалтын үр дүнтэй загвар нь эрсдэлд суурилсан уян хатан зохицуулалт, инновацад ээлтэй туршилтын орчин (сэндбокс), хэрэглэгчийн эрх болон мэдээллийн хамгаалалтыг бэхжүүлэх бодлого, зохицуулалтын болон хяналтын технологийн хэрэглээ, мөн хил дамнасан зохицуулалтын хамтын ажиллагаанд тулгуурлаж байна. Түүнчлэн Бразил, Их Британи, Европын Холбоо зэрэг орнуудад нээлттэй санхүүгийн экосистемийг хөгжүүлэх бодлого хэрэгжиж, хэрэглэгчийн өгөгдлийг гуравдагч этгээдтэй аюулгүй солилцох боломжийг бүрдүүлж байна. Иймээс финтекийн зохицуулалт нь уламжлалт санхүүгийн хууль эрх зүйн тогтолцооны хүрээг давж, технологийн шинэчлэлд хурдан хариу үйлдэл үзүүлэх, инновацыг дэмжихийн зэрэгцээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан тэнцвэртэй бодлогын чиглэлд хөгжиж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн салбар дахь технологийн дэвшил нь санхүүгийн үйлчилгээний хэлбэр, зах зээлийн бүтэц, хүрэх сувгийг өөрчилж, зохицуулагч байгууллагуудын бодлого, хандлагад шинэ шаардлага бий болгож байна. Энэхүү судалгаагаар улс орнууд финтек үйлчилгээний хөгжлийг хатуу хязгаарлах бус, эрсдэлд суурилсан, уян хатан зохицуулалтын арга хэрэгслийг ашиглан зохицуулж байгааг харууллаа. Зарим улс орон финтекийг бүхэлд нь хамарсан тусгай хууль баталж байгаа бол нөгөө хэсэг нь салбарын хууль тогтоомждоо үе шаттай өөрчлөлт оруулах замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулж байна. Мөн олон оронд зохицуулалтын сэндбоксыг шинэ үйлчилгээний эрх зүйн статусыг тодорхойлох, зохицуулалтын шаардлагыг боловсронгуй болгох туршилтын механизм болгон ашиглаж байгаа бөгөөд амжилттай туршигдсан бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрлийн шинэ ангилал бий болгох, түр зөвшөөрөл олгох, эсвэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар албан ёсны зах зээлд нэвтрүүлж байна. Харин Монгол Улсад финтек салбарын өсөлт эрчимжиж байгаа хэдий ч шинэ үйлчилгээ зах зээлд нэвтрэхэд эрх зүйн тодорхой бус байдал үүсэх, зохицуулагч байгууллагуудад тухайн үйлчилгээг бүртгэх, зөвшөөрөх эрх зүйн боломж хязгаарлагдмал байх зэрэг асуудал тулгарч байна. Иймээс салбарын хууль тогтоомжийг илүү ерөнхий, уян хатан байдлаар шинэчлэх, эрсдэлд суурилсан зохицуулалтыг нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд түр зөвшөөрөл болон завсрын зохицуулалтын хэрэгсэл ашиглах, мөн зарчимд суурилсан зохицуулалт, нээлттэй санхүү, өгөгдлийн аюулгүй байдлын стандартыг зохицуулалтын бодлогод тусгах замаар инновацыг дэмжсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2017). Fintech and RegTech in a Nutshell, and the Future in a Sandbox. SSRN Electronic Journal.
- ◆ Gomber, P., Kauffman, R. J., Parker, C., & Weber, B. W. (2018). On the Fintech Revolution: Interpreting the Forces of Innovation, Disruption, and Transformation in Financial Services. *Journal of Management Information Systems*.
- ◆ Catalini, C., & Gans, J. S. (2016). Some Simple Economics of the Blockchain. MIT Sloan Research Paper.
- ◆ Gai, K., Qiu, M., Sun, X., Zhao, H., & Zhang, Y. (2018). Application of Artificial Intelligence in Fintech: A Review.
- ◆ World Bank (2020). The Global Fintech Report.
- ◆ IMF (2019). The Rise of Digital Money. IMF Fintech Notes.
- ◆ Allen, H. J. (2019). Driverless finance. *Georgetown Law Journal*, 108(5), 1025–1076.
- ◆ Buckley, R. P. et al. (2021). Building fintech ecosystems: Regulatory sandboxes, innovation hubs and beyond. *Washington Univ. Journal of Law & Policy*, 65, 147–182.
- ◆ Jenik, I., & Lauer, K. (2017). Regulatory sandboxes and financial inclusion. CGAP.
- ◆ Pasti, F. et al. (2020). The role of regulation in shaping fintech innovation: The case of Kenya. World Bank.
- ◆ Zetzsche, D. A. et al. (2017). Regulating a revolution: From regulatory sandboxes to smart regulation. *Fordham Journal of Corporate & Financial Law*, 23(1), 31–103.
- ◆ MAS (Monetary Authority of Singapore). (2022). FinTech Regulatory Approach.
- ◆ Astana Financial Services Authority (AFSA). (2023). Annual FinTech Report.
- ◆ Zetzsche, D. A., Buckley, R. P., Arner, D. W., & Barberis, J. N. (2017). From FinTech to TechFin: The Regulatory Challenges of Data-Driven Finance. *NYU Journal of Law & Business*.
- ◆ Financial Conduct Authority (FCA). (2023). FinTech and Innovation Hub Report.
- ◆ Monetary Authority of Singapore (MAS). (2022). Singapore Fintech Strategy Overview.
- ◆ European Commission. (2018). Revised Payment Services Directive (PSD2).
- ◆ Financial Services Commission of Korea. (2020). Fintech Sandbox Report.
- ◆ Astana International Financial Centre (AIFC). (2021). Regulatory Sandbox Overview.
- ◆ Bangko Sentral ng Pilipinas (BSP). (2022). Digital Payments Transformation Roadmap.
- ◆ Monetary Authority of Singapore (MAS). (2016). FinTech Regulatory Sandbox Guidelines. <https://www.mas.gov.sg>
- ◆ Monetary Authority of Singapore (MAS). (2020). Overview of the Regulatory Sandbox and Sandbox Express. <https://www.mas.gov.sg>
- ◆ Low, K. (2021). Fintech Regulation in Singapore: Legal Infrastructure and Innovation. *Singapore Journal of Legal Studies*, 1(1), 25–42.

- ◆ Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2016). The Evolution of Fintech: A New Post-Crisis Paradigm? *Georgetown Journal of International Law*, 47(4), 1271–1319.
- ◆ Financial Conduct Authority. (2020). Regulatory Sandbox Lessons Learned Report. <https://www.fca.org.uk>
- ◆ Financial Services and Markets Act 2000, Part 4A. <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/8/contents>
- ◆ Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2017). FinTech and RegTech: Impact on Regulators and Banks. *Journal of Banking Regulation*, 19(4), 1–14.
- ◆ Financial Conduct Authority (FCA). (2015). Regulatory Sandbox – Project Innovate. <https://www.fca.org.uk/>
- ◆ AIFC FinTech Rules. (2021). Astana Financial Services Authority. <https://afsa.aifc.kz>
- ◆ AFSA. (2020). Digital Financial Services Development Roadmap 2020–2025. Astana Financial Services Authority.
- ◆ AFSA. (2021). Regulatory Sandbox Guidelines. <https://afsa.aifc.kz>
- ◆ BSP. (2021a). BSP Regulatory Sandbox Framework (Circular No. 1108). Bangko Sentral ng Pilipinas. <https://www.bsp.gov.ph>
- ◆ BSP. (2021b). FinTech Roadmap and Digital Payments Transformation Strategy 2020–2023. Bangko Sentral ng Pilipinas.
- ◆ Zetsche, D. A., Buckley, R. P., Arner, D. W., & Barberis, J. N. (2017). Regulating a Revolution: From Regulatory Sandboxes to Smart Regulation. *Fordham Journal of Corporate & Financial Law*, 23(1), 31–103.
- ◆ European Commission. (2022). Digital Finance Strategy for the EU. Brussels. <https://finance.ec.europa.eu>
- ◆ European Commission. (2023). EU Digital Finance Sandbox Overview. Brussels.
- ◆ Zetsche, D. A., Arner, D. W., Buckley, R. P. (2020). Decentralized Finance (DeFi). University of Hong Kong Faculty of Law Research Paper No. 2020/030
- ◆ Bank of Lithuania. (2020). The Regulatory Sandbox Concept. <https://www.lb.lt>
- ◆ Bank of Lithuania. (2021). Fintech Guidelines and Newcomer Programme. <https://www.lb.lt>
- ◆ Bank of Lithuania. (2022). Licensing decisions and sandbox results. <https://www.lb.lt>
- ◆ Commission de Surveillance du Secteur Financier. (2020). Innovation Hub and Support to FinTech. <https://www.cssf.lu>
- ◆ Luxembourg House of Financial Technology (LHoFT). (2021). Fintech Programmes and Regulatory Collaboration. <https://lhof.com>
- ◆ CSSF. (2022). Annual Report: Regulatory developments on digital finance. <https://www.cssf.lu>
- ◆ Financial Services Commission (FSC). (2019). Financial Innovation Support Act Overview. Retrieved from: <https://www.fsc.go.kr>
- ◆ FSC. (2020). Korea's Fintech Regulatory Landscape. <https://www.fsc.go.kr>
- ◆ FSC. (2021). Post-sandbox evaluation and licensing criteria. Retrieved from: <https://www.fsc.go.kr>
- ◆ Park, J. (2022). South Korea's regulatory sandbox: Balancing innovation and consumer protection. *Asian Journal of Law and Economics*, 13(1), 45–62.
- ◆ Financial Services Agency (FSA). (2020). Approach to FinTech Regulation and Sandbox in Japan. Retrieved from: <https://www.fsa.go.jp>
- ◆ Ministry of Economy, Trade and Industry (METI). (2018). Launch of the Regulatory Sandbox System in Japan. <https://www.meti.go.jp>

- ◆ Nakazato, K. (2020). Japan's Sandbox Strategy: Innovation without Deregulation? *Journal of Japanese Law*, 25(1), 38–52.
- ◆ IMF. (2021). Japan: Financial Sector Assessment Program. Retrieved from: <https://www.imf.org>
- ◆ People's Bank of China (PBOC). (2020). Notice on the Launch of Fintech Innovation Regulatory Trial in Beijing. Retrieved from: <http://www.pbc.gov.cn>
- ◆ IMF. (2022). People's Republic of China: Financial Sector Assessment Program – Technical Note. <https://www.imf.org>
- ◆ Liu, H. (2022). China's Regulatory Sandbox: Experimental Governance under State Control. *Asia-Pacific Journal of Financial Studies*, 51(3), 210–235.
- ◆ KPMG China. (2021). Fintech in China: Regulation and Innovation. Retrieved from: <https://home.kpmg/cn>
- ◆ CNBV (2021). Guía de modelos novedosos bajo la Ley Fintech. Comisión Nacional Bancaria y de Valores.
- ◆ Ley para Regular las Instituciones de Tecnología Financiera (2018). Gobierno de México.
- ◆ OECD (2020). Digital Innovation in Financial Services in Mexico: Fintech Regulation and Development. <https://www.oecd.org>

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ГЭЖ ЮУ ВЭ?

- ✓ Монгол улсын мөнгөн тэмдэгтийг гадаад улсын мөнгөн тэмдэгтээр солих үйл ажиллагаа юм.
- ✓ Уг арилжааг валют арилжааны тусгай зөвшөөрөлтэй Банк бус санхүүгийн байгууллага эрхэлнэ.



АЛБАН БУС АРИЛЖАА ХИЙХ НЬ ДАРААХ ЭРСДЭЛТЭЙ



Хуурамч мөнгөн
дэвсгэрт авах



Санхүүгийн луйвар,
залиланд өртөх



Баримтгүй гүйлгээ
маргаан нотлогдох
боломжгүй.



Бодит ханшаас
зөрүүтэй үнээр
алдагдалтай арилжих

ГАДААД ВАЛЮТ АРИЛЖИХДАА АНХААРНА УУ !

1. Зөвшөөрөлтэй байгууллага сонгох

Албан ёсны хаяг, тэмдэглэгээтэй байх
 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй байх



2. Ханшийн мэдээлэл ил тод байх

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
Америк доллар	USD	
Евро	EUR	
Английн фунт	GBP	
Оросын рубль	RUB	
Хятадын юань	CNY	
БНСУ-н Вон	KRW	

Нийтэд ханшийн мэдээллийг ил тод электрон самбар байршуулсан байх

3. Хуурамч мөнгөн дэвсгэрт шалгах нөхцөл бүрдсэн байх

Хуурамч мөнгөн дэвсгэрт шалгах төхөөрөмжтэй байх



4. Гүйлгээ хуульд нийцсэн байх:



Байгууллагын албан ёсны дансаар гүйлгээ хийх .

5. Баримт авах

Хууль зүйн баталгаа болох тул гадаад валют солилцсон санхүүгийн баримт авах



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АЛТНЫ ҮНЭ БУУРЛАА.



Алтны ханш буурлаа. Энэ нь ам.долларын ханш чангарч, АНУ-ын төв банк ойрын хугацаанд бодлогын хүүгээ бууруулах магадлал багассантай холбоотой гэж шинжээчид үзэж байна.

Спот алтны үнэ 1.6 хувиар буурч, нэг унц нь ойролцоогоор 4,335 ам.долларт хүрсэн нь сүүлийн саруудын доогуур түвшний нэг болжээ. Мөн алтны фьючерс үнэ ч мөн адил буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Шинжээчдийн тайлбарласнаар ам.долларын ханш өсөх үед алт бусад валют эзэмшигчдэд илүү үнэтэй болж харагддаг тул эрэлт буурах хандлагатай байдаг. Үүний зэрэгцээ дэлхийн зах зээлд инфляцын дарамт өндөр хэвээр байгаа нь төв банкууд бодлогын хүүгээ өндөр түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь хүүгийн орлого өгдөггүй алтны эрэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн Ойрх Дорнод дахь геополитикийн нөхцөл байдал, ялангуяа Ирантай холбоотой хурцадмал байдал газрын тосны үнийг өсгөж, инфляц нэмэгдэх эрсдэлийг хадгалж зах зээлд тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж байна.

Түүнчлэн мөнгө, платинум, палладий зэрэг бусад үнэт металлын үнэ буурсан үзүүлэлттэй гарчээ.

Шинжээчдийн үзэж буйгаар ам.долларын ханш өндөр хэвээр байж, АНУ-ын төв банк ойрын хугацаанд бодлогын хүүгээ бууруулахгүй гэсэн хүлээлт давамгайлсан хэвээр

байвал алтны үнэ богино хугацаанд савлагаатай хэвээр байх төлөвтэй байна.

Эх сурвалж: www.reuters.com

ДОНАЛЬД ТРАМП ИРАНЫ ЦАХИЛГААН СТАНЦ РҮҮ ХИЙХ ЦОХИЛТУУДЫГ ХОЙШЛУУЛСНААР УОЛЛ СТРИЙТИЙН ИНДЕКСҮҮД ӨСӨВ.

2026.03.23. АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо



хоногт уналттай байсан ч Трампын мэдэгдлийн дараа газрын тосны үнийг буулгаснаар зах зээлийг сэргээсэн байна.

Индексүүдийн хөдөлгөөн:

- ◆ Dow Jones Industrial Average нь 631.00 пункт буюу 1.38%-иар өсөж 46,208.47 болсон.
- ◆ S&P 500 нь 74.52 пункт буюу 1.15%-иар өсөж 6,581.00 хүрсэн.
- ◆ Nasdaq Composite нь 299.15 пункт буюу 1.38%-иар өсөж 21,946.76 болсон.
- ◆ CBOE-ийн Волатиль индекс нь сүүлийн хоёр долоо хоногийн хамгийн өндөр түвшнээс буурч 26.15-д хаагдсан.

S&P 500-ийн бүх 11 салбарын индекс өсөлттэй байсан бөгөөд хэрэглээний салбарууд 2.46%-иар тэргүүлсэн бол эрүүл мэнд болон хэрэглээний тогтвортой салбарууд сул өсөлттэй байв.

Эх сурвалж: www.reuters.com

ОЙРХИ ДОРНОДЫН ГАЛ ЗОГСООХ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ГАРСНААР ХУВЬЦААНЫ ҮНЭ ӨСЧ, ГАЗРЫН ТОСНЫ ҮНЭ БУУРЧ БАЙНА.



Ойрхи Дорнодын дайнд 1 сарын гал зогсоох хэлэлцээ явагдаж магадгүй гэсэн мэдээллийн дараа дэлхийн санхүүгийн зах зээлд эерэг хандлага ажиглагдлаа.

- ◆ S&P 500 фьючерс Азийн арилжаанд +0.9%;
- ◆ Европын фьючерсүүд +1.2%;
- ◆ Brent нефть –6% буурч \$98.30/баррельт хүрэв6

АНУ Иранд 15 зүйл бүхий энхийн санал хүргүүлж, уг төлөвлөгөөг хэлэлцэхийн тулд 1 сарын гал зогсоох санал тавьсан талаар мэдээлсэн.

Зах зээлүүд дайныг зогсоох боломжийн талаар гарч буй мэдээлэлд эерэг хариу үзүүлж байгаа ч Хормүзийн хоолойгоор газрын тосны тээвэр хэзээ бүрэн сэргэх нь тодорхойгүй хэвээр байна.

Мөн валютын зах зээлд:

- ◆ ам.доллар 158.8 иен
- ◆ евро \$1.1620 орчимд арилжаалагдсан байна.

Шинжээчдийн үзэж байгаагаар зах зээл одоогоор мэдээллийн урсгалд шууд хариу үйлдэл үзүүлж байгаа бөгөөд хэлэлцээ бодитоор ахиц гаргах эсэх тодорхойгүй тул хэлбэлзэл үргэлжилэх магадлалтай байна.

Эх сурвалж: www.reuters.com

WORLD FINANCE

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр

S&P 500 / ^GSPC/

6,556.37 -24.63 (-0.37%)



Gold Apr 26 (GC=F)

4,555.40 +153.40 (+3.48%)




FTSE 100 / ^FTSE/

9,965.16 +71.01 (+0.72%)



NASDAQ Composite (^IXIC)

21,761.89 -184.87 (-0.84%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

 **1-110**
Авлигыг мэдээлэх утас